



**ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ
ХАЛДВАРТ ӨВЧИН СУДЛАЛЫН
ҮНДЭСНИЙ ТӨВ**

13335 Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,
Нам Ян Жуучийн гудамж 32/1, Утас: 45 39 94,
Факс: (976-11) 45 86 99, E-mail: info@nccd.gov.mn,
<http://www.nccd.gov.mn>

2024. 12. 09 № З-3/1152.

танай _____ -ны № _____ -т

Г

Г

Үнийн санал ирүүлэх тухай

Тус төвөөс Сүрьеэгийн идэвхтэй илрүүлэлтийн зардлын өртөг үр ашгийн үнэлгээ хийх ажлыг гүйцэтгүүлэх гэж байгаа тул “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээг худалдан авах тухай” хуулийн 7 дугаар зүйлийн 7.3-д заасны дагуу үнийн саналыг 2024 оны 12-дугаар сарын 16-ны өдрийн дотор tender@nccd.gov.mn цахим хаягаар ирүүлнэ үү.

Хавсралт хуудастай.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Э.АНХБАЯР

My document/2024 alban toot

Халдварт өвчин судлалын үндэсний
төвийн 2024 оны 3-ийн дугаартай
албан бичгийн хавсралт

9024040027
9077901 ГС17672

Нэр: Сүрьеэгийн идэвхтэй илрүүлэлтийн зардлын өртөг үр ашгийн
үнэлгээ

Зорилго: 2021-2023 онд сүрьеэгийн идэвхтэй илрүүлэлтэд
зарцуулсан хөрөнгө, санхүүжилтийг тодорхойлох, тулгамдаж буй
бэрхшээл, асуудлыг тодорхойлох, зөвлөмж гаргах

Эхлэх хугацаа: 2023 оны 12 дугаар сарын 16 ны өдөр

Дуусах хугацаа: 2024 оны 03 дугаар сарын 31 ний өдөр

Байршил: Халдварт өвчин судлалын үндэсний төв

1	Зорилт	<ol style="list-style-type: none">Сүрьеэгийн идэвхтэй илрүүлэлтийг зохион байгуулахад гарсан санхүүжилтийг тооцохТулгамдаж буй асуудлыг тодорхойлж, зөвлөмжийг боловсруулах
2	Үндэслэл	<p>2017 оноос эхлэн сүрьеэгийн тусламж үйлчилгээний журам, зааврын дагуу идэвхтэй илрүүлэлтийг зохион байгуулж, илрүүлэлтийг нэмэгдүүлэхийг зорьж, хамгийн мэдрэг үзүүлэлттэй өндөр өртөг бүхий оношилгооны тоног төхөөрөмжүүдийг шат дараалалтайгаар нэвтрүүлж, аймаг дүүрэгт ханган нийлүүлсэн ч илрүүлэлтэд төдийлөн нөлөө үзүүлэхгүй, нийт бүртгэгдсэн тохиолдлын 10% орчим хувийг илрүүлсэн байна. Энэхүү үйл ажиллагаанд хөрөнгө мөнгийг зарцуулсан хэвээр байна.</p> <p>Иймд сүрьеэгийн идэвхтэй илрүүлэлтийн зарцуулалт, өртөг үр ашгийн үнэлгээг хийж цаашид ашигтай зардлын аргуудыг тодорхойлох шаардлагатай байна.</p>
3	Хамрах хүрээ	Засгийн газар, орон нутгийн засаг захиргаа болон Глобаль сан дэмжлэгтэй хийгдсэн сүрьеэгийн идэвхтэй илрүүлэлт
4	Цар хүрээ	<ol style="list-style-type: none">Үнэлгээний арга аргачлал боловсруулахҮнэлгээний талбар мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийхҮнэлгээний тайлан бичихҮнэлгээний үр дүнг танилцуулах уулзалт зохион байгуулахҮнэлгээний тайланг хэвлүүлэн, хүлээлгэн өгөхГэрээ дүгнэсэн акт үйлдэх, хүлээж авахҮйл ажиллагааны болон санхүүгийн тайлан боловсруулж хүлээлгэж өгөх

My document/2024 alban toot

5	Үнэлгээ хийх байгууллагад тавигдах шаардлага	Үнэлгээ, судалгаа, шинжилгээний ажил 8-аас доошгүй жил, эрхэлсэн, ажлын дадлага, туршлагатай, ажлын даалгаврыг бүрэн гүйцэтгэх хангалттай мэдлэг, үр чадвартай, байгууллагын чиг үүрэг, хүний нөөц, хууль тогтоомжид үнэлгээ, шинжилгээ хийх, санал дүнэлт ⁷⁷ боловсруулах чадвартай судлаач бүхий төрийн болон төрийн бус байгууллага, сургалт эрдэм шинжилгээний байгууллага байх Өмнө нь ижил төрлийн үнэлгээ, хөтөлбөр боловсруулах ажил гүйцэтгэж байсныг давуу тал гэж үзнэ.
6	Тайлангийн хуваарь	Гэрээ байгуулж ажил гүйцэтгэж эхэлсэн өдрөөс хойш хуанлийн 20 хоног тутамд ажлын явц үр дүнг тайлагнаж байна.
7	Хүлээгдэж буй үр дүн	Ажлын даалгаврын дагуу боловсруулсан тайлан, судалгааны материал, холбогдох байгууллага, албан тушаалтнуудад хандсан зөвлөмжийн төсөл байна.
8	Гүйцэтгэх ажлын шаардлага	Үнэлгээний эх нь Монгол хэл дээр бичигдсэн байна. Үнэлгээ нь агуулгын хувьд харилцан уялдаатай, иж бүрэн шинжлэх ухааны судалгааны тодорхой арга зүйд үндэслэсэн, эрэлт хэрэгцээнд нийцсэн, онол практикийн ач холбогдол бүхий байна. Үнэлгээ / тайлан, төсөл, судалгаа, санал, зөвлөмж/-ний хэлбэржүүлэлт / формат/ нь төрийн албан хэрэг хөтлөлтийн журам, судалгааны ажилд тавигдах нийтлэг шаардлагад нийцсэн, хэл зүйн болон утга найруулгын алдаагүй байна.
9	Төлбөрийн нөхцөл	Төлбөрийг Монгол төгрөгөөр олгох бөгөөд ажлын хөлсөнд холбогдох бүх зардал, татвар зэрэг багтсан байна.
10	Санал ирүүлэх	Шалгаруулалтыг бага үнийн аргаар явуулна. Дээрх шаардлагыг хангасан этгээд дараах бичиг баримтыг бүрдүүлэн tender@nccd.gov.mn -ээр илрүүлнэ.